



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/80

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 60.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын бага сургуулийн барилгын их засварын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

С.Магнайбаяр (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

С.Аюурзана (Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГазрын инженер)

С.Мандахбаатар (Иргэдийн хурлын төлөөлөгч)

Д.Дашдаваа (Иргэний төлөөлөл), (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)


Нарийн бичгийн дарга:

Г.Ундармаа (Төв аймгийн Орон нутгийн газрын худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (С.Магнайбаяр)-д, ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122010247